



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 164.

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 134 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын тухай журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.



Б.МОНХЦЭЦЭГ

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
2017 оны 05 сарын 02-ны өдрийн  
164 тогтоолын хавсралт

Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт,  
зарцуулалтын тухай журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Засаг даргын Нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын тухай журмын дагуу урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай зарим зардлыг санхүүжүүлэх болон дүүргийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх зориулалт бүхий Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнахад энэ журмыг мөрдөнө.

Хоёр. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт

Засаг даргын нөөц хөрөнгийг дараах зориулалтаар төлөвлөж дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна. Үүнд:

2.1 Улс орныг хамарсан болон дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан гамшигт үзэгдэл /ган, зуд, үер, салхи, шуурга, газар хөдлөлт, хүн, мал амьтны болон ургамлын халдварт өвчин, хортон мэрэгчид тархах г.м/ тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, урьдчилан сэргийлэх

2.2 Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химиийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах

2.3 Засаг даргын Төсвийн тухай болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дүүргийн хөгжил, цаашдын чиг хандлагатай холбоотой бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр томилогдон ажиллах эрдэмтэн, судлаач, мэргэжилтэнд олгох урамшил, Засаг даргад байгууллага, иргэдээс санхүүгийн дэмжлэг хүсэж ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх, байгууллага, иргэдэд шагнал олгох, гадаад, дотоодын зочин төлөөлөгчдийг хүлээн авах, олон улсын байгууллага, гадаад улс орны урилгаар айлчлал хийхтэй холбогдсон зардал, дүүргийн нэрэмжит боловсрол, соёл, урлаг, спортын тэмцээн, наадам

зохион байгуулах, тив, дэлхий, улсын аварга шалгаруулах тэмцээн уралдаанд оролцох болон амжилттай оролцсон баг тамирчдыг урамшуулах, дүүргийн түүхэн тэмдэглэлт ойг тохиолдуулан дүүргийн ахмад настнууд, төрийн албан хаагчдад бэлэг дурсгал гардуулах, хүндэтгэл үзүүлэх

2.4 арга хэмжээ, дүүргийг гадаад дотоодод сурталчлах, соёлын өдрүүд зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэх

2.5 Төсвийн жилийн дундуур шинээр батлагдан гарсан хууль, тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Засгийн газар, дээд шатны байгууллагын шийдвэрээр санхүүжүүлэхийг даалгасан тодорхой нэр заасан үйл ажиллагаа, арга хэмжээг санхүүжүүлэх

2.6 Нийтийг хамарсан аюул болон гамшгийн аюулаас хохирсон иргэдэд тэтгэмж, тусlamж олгох, ослын үр дагаврыг арилгах чиглэлээр арга хэмжээ авах, гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг, тусlamж үзүүлэх

2.7 Амьдралын нэн хүнд нөхцөлтэй, орон гэргүй тэнэмэл иргэд, хүүхдүүдэд зориулан гэр олгох, санхүүгийн дэмжлэг тусlamж үзүүлэх

2.8 Дүүргийн төрийн албан хаагчийн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад хамрагдах, амьдрах нөхцөлийг сайжруулах, гэр, орон сууцтай болоход нь туслалцаа үзүүлэх, амьдралд нь гачигдал тохиолдсон үед дэмжлэг үзүүлэх, магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан төрийн албан хаагчдын эмчилгээний зардлын зохих хэсгийг хариуцах зэргээр нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх

2.9 Батлан хамгаалах арга хэмжээ, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах

2.10 Хог хаягдлыг цэвэрлэх, агаарын болон орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, арилгах

2.11 Хууль, тогтоомж, журамд засан бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд санхүүжүүлэх

2.12 Засаг даргын нөөц хөрөнгийг тухайн жилийн төсөвт дүнгээр нь батална.

Гурав. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт,  
гүйцэтгэлийг тооцох журам

3.1. Засаг даргын нөөц хөрөнгөөс зардал гаргах нөхцөлд хариуцан гүйцэтгэх байгууллага, албан хаагч, ажилтан уг арга хэмжээг хэрэгжүүлэх саналын төлөвлөгөө, төсвийн зардлын дэлгэрэнгүй тооцоог Засаг даргын Тамгын газар ирүүлнэ.

3.2. Засаг даргын Тамгын газар төсвийн зардлын тооцоог Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулан холбогдох газар, хэлтсээс санал авч, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Засаг даргын захирамж гаргуулна.

3.3. Засаг даргын захирамжийг үндэслэн Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжигдэх арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг олгоно.

3.4. Засаг даргын нөөц хөрөнгийг эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээг гүйцэтгэгч байгууллага хэмнэлт гаргасан бол уг арга хэмжээ хэрэгжиж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор үлдэгдлийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд эргүүлэн шилжүүлнэ.

3.5. Тухайн арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, албан хаагч ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

3.6. Зардлын тайланг гаргахдаа уг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, няглан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана.

3.7. Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон зардлыг зориулалт бусаар буюу өөр зүйлд шилжүүлэх зарцуулахыг хориглоно. Хэрэв тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бараа, материал, ажил үйлчилгээг тухайн үеийн зах зээлийн үнэ тарифаас дээгүүр үнээр бэлтгэсэн буюу хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, үр ашиггүй зардал гаргасан байвал тухайн байгууллагын санхүүжилтээс суутган тооцож дарга, няглан бодогчид нь зохих журмын дагуу хариуцлага ногдуулна.

3.8. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг Засаг даргын Тамгын газрын няглан бодогч хариуцан гүйцэтгэнэ.

3.9. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад Санхүү, төрийн сангийн хэлтэс хяналт тавьж зардлын гүйцэтгэл, эх үүсвэрийн үлдэгдлийн мэдээг тооцон гаргаж дүнг улирал бүр Засаг даргад танилцуулж байна.